



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 09 дугаар сарын 14

Дугаар 16/02

Баян-Өндөр сум

Эрдэнэт хот, Хөдөө аж ахуйн
2023-2024 оны өвөлжилтийн
бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7, 20.1.9, 20.1.18, 20.1.21, 20.1.22, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.15 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймаг Эрдэнэт хот, Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэн, төлөвлөгөөний биелэлтийг сайтар хангаж ажиллахыг холбогдох төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

2.Аймгийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлсэн ажлын талаар болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд 2023 оны 10 дугаар сарын 16-ны дотор танилцуулахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ